БАТЛАВ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Н.ЦАГААНХҮҮ

# БУЯНТ-УХАА БООМТ ДАХЬ ХИЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН АЛБАНЫ 2019 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Мэргэжлийн хяналтын байгууллагаас 2019 оныг **"Иргэн төвтэй, үр дүнд чиглэсэн төрийн үйлчилгээг төлөвшүүлэх"** жил болгож, энэ хүрээнд дараах зорилтыг дэвшүүлж байна.

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | | Хугацаа | Хариуцах нэгж |
|---|---|---|---|---|---|
| | | Суурь түвшин буюу өмнөх оны үзүүлэлт | Тухайн жилийн хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| *Мэргэжлийн хяналтын байгууллагын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2 дугаар зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд:*<br>**Нэг. "Хүн, мал, амьтны гоц халдварт өвчин, ургамлын хорио цээртэй зүйлс хил дамжин тархахаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний чадавхыг сайжруулах, импорт, экспортын барааны аюулгүй байдлыг ханган, гадаад худалдаа эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх" зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ:** | | | | | |
| 1.1 | Олон улсад шуурхай болон тогтмол мэдээлэх хүний хөл хориот өвчин улсын хилээр дамжин тархахаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах чадавхыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах | ДЭМБ-ын хилийн нэвтрэх цэгүүдэд ОУЭМД-ийн хэрэгжилтийг үнэлсэн ОУ-ын үнэлгээний багийн үнэлгээгээр чадавхтай /3 оноо/ гэж үнэлэгдсэн.<br>Бэлэн байдлын нөөцийн /хувийн хамгаалах хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодис гэх мэт/түвшинд 2 оноо буюу "чадавхжиж байгаа" гэж тус тус үнэлэгдсэн. | Нийгмийн эрүүл мэндэд нөлөөлөх, ноцтой байдал үүсгэх халдварт өвчин дамжин тархахаас урьдчилан сэргийлэгдсэн байна.<br><br>Тохиолдлын удирдлагын тогтолцоог нэвтрүүлж, улсын /ахлах/ байцаагчдын хариу арга хэмжээ авах чадавх дээшилсэн байна.<br><br>Хилийн нэвтрэх цэгийн бэлэн байдлын нөөцийн түвшин нэмэгдсэн байна. | Жилдээ | Хяналт шалгалт, эрсдэлийн удирдлагын хэлтэс |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1.2 | Хил, дамжин халдварлах эрсдэл бүхий мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж, хилээр нэвтрүүлж буй мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд мал эмнэлэг, хорио цээрийн хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулах | 2018 онд мал эмнэлэг, хорио цээрийн хяналт шалгалтаар зөрчил илрээгүй. | Мал эмнэлэг, хорио цээрийн олон улсын гэрээ, конвенци, Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдана.<br><br>Мал, амьтны гоц халдварт өвчин хил дамнан халдварлах эрсдэл гарсан үед хариу арга хэмжээг оновчтой төлөвлөн ажилласан байна.<br><br>Экспорт, импортын мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлыг хангах чиглэлээр гарсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь дээшилсэн байна. | Жилдээ | Хяналт шалгалт, эрсдэлийн удирдлагын хэлтэс |
| 1.3 | Хилээр нэвтрүүлж буй ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, ургамал хамгаалах бодист хорио цээр, аюулгүй байдлын хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах | Гадаад хорио цээртэй ургамлын өвчин, хортон шавж, хог ургамал хил дамнан тархах эрсдэл байна.<br><br>Ургамлын хорио цээрийн хяналтын чиглэлээр 3 зөрчил илэрсэн нь нийт зөрчлийн 7 хувийг эзэлж байна. | Ургамал хорио цээрийн олон улсын гэрээ, конвенци, Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдана.<br><br>Гадаад хорио цээртэй ургамлын өвчин, хортон шавж, хог ургамал хил дамнан тархах эрсдэлийг бууруулж, импортын ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлыг хангасан байна.<br><br>Экспорт, импортын ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний хорио цээр, чанар аюулгүй байдлыг хангах чиглэлээр гарсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь дээшилсэн байна. | Жилдээ | Хяналт шалгалт, эрсдэлийн удирдлагын хэлтэс |
| 1.4 | Экспорт, импортын хүнсний болон бусад | Экспортын боловсруулсан хүнс | Экспорт, импортын хүнс болон | Жилдээ | Хяналт |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | бараанд хүнсний чанар, стандартын болон эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналт шалгалт хийх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах | болон хүнсний бус барааны талаарх хууль тогтоомжийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна.<br>Импортын хүнсний бус барааны /хүүхдийн тоглоом, гоо сайхан ахуйн хэрэглээний бараа гэх мэт/ талаарх хууль тогтоомжийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй.<br>Хүнсний чанар, стандартын хяналтын чиглэлээр 2 зөрчил илэрсэн нь нийт зөрчлийн 4.7 хувийг эзэлж байна.<br>Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр 7 зөрчил илэрсэн нь нийт зөрчлийн 16.3 хувийг эзэлж байна. | хүнсний бусад бараа бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал хангагдаж эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.<br><br>Экспорт, импортын хүнсний бүтээгдэхүүний талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувийг нэмэгдүүлсэн байна.<br><br>Хилээр нэвтрүүлсэн чанар, аюулгүй байдлын баталгаатай хүнсний бүтээгдэхүүний тоо хэмжээг нэмэгдүүлж зөрчил дутагдал буурсан байна. | | шалгалт, эрсдэлийн удирдлагын хэлтэс |
| 1.5 | Экспорт, импортын эм биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэлд хяналт хийх ажлыг зохион байгуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах | Эм биобэлдмэлийн хяналтын чиглэлээр 31 зөрчил илэрсэн нь нийт зөрчлийн 72 хувийг эзэлж байна. | Улсын хилээр хориглосон хязгаарласан, чанар аюулгүй байдал алдагдсан эм, биобэлдмэл, эмийн түүхий эд, вакцин, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, биологийн идэвхит бүтээгдэхүүн нэвтрэхгүй байна. | Жилдээ | Хяналт шалгалт, эрсдэлийн удирдлагын хэлтэс |
| 1.6 | Импортын химийн хорт болон аюултай бодист хяналт хийх ажлыг зохион байгуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах | Химийн хорт болон аюултай бодисыг импортлох, тээвэрлэх үед эрсдэлтэй байна. | Чанар, стандартын шаардлага хангасан бодис бараа бүтээгдэхүүн улсын хилээр нэвтрэх нөхцөл бүрдэнэ. | Жилдээ | Хяналт шалгалт, эрсдэлийн удирдлагын хэлтэс |
| 1.7 | Импорт, экспортын ашигт малтмал, газрын тосны бүтээгдэхүүнд хяналт хийх ажлыг зохион байгуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах | Импорт, экспортын ашигт малтмал, газрын тосны бүтээгдэхүүний талаарх хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдаж байна. | Импорт, экспортын ашигт малтмал, газрын тосны бүтээгдэхүүнийг импортлох, тээвэрлэх үеийн шаардлагын хэрэгжилтийг нэмэгдүүлсэн байна. | Жилдээ | Хяналт шалгалт, эрсдэлийн удирдлагын хэлтэс |
| 1.8 | Улсын хил дээр цацрагийн хяналтын төхөөрөмжөөр хяналт шалгалт хийж, цөмийн | Хяналт шалгалтаар зөрчил дутагдал илрээгүй. | Боомтоор нэвтэрч байгаа цацраг идэвхт материалын тээвэрлэлт, | Жилдээ | Хяналт шалгалт, |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | болон цацраг идэвхт бодис хууль бусаар нэвтрэхээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах | | цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдал, цацраг идэвхт материалын хяналт олон улсын түвшинд зохион байгуулагдаж, урьдчилан сэргийлж, тоног төхөөрөмжийн бэлэн байдал хангагдана. | | эрсдэлийн удирдлагын хэлтэс |
| *Мэргэжлийн хяналтын байгууллагын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1 дүгээр зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд:*<br>**Хоёр. “Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлж иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллаж амьдрах нөхцөл, боломжийг бүрдүүлэх” зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ:** | | | | | |
| 2.1 Объектын эрсдэлийн ангиллыг үндэслэн их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нийт объектод хяналтын чиглэлээр хяналт шалгалтыг хийх | | | | | |
| 2.1.1 | Хилийн бүсэд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдалд /Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналт, Хүнсний чанар стандартын хяналт/-аар шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах. | 2018 онд нийт 6 аж ахуйн нэгжид 2 чиглэлээр хяналт шалгалт хийсэн.<br><u>Хүнсний чанар, стандартын хяналтаар</u><br>Буянт-Ухаа трейд ХХК /Дунд эрсдэлтэй-29/<br>Номадс хоспиталити ХХК /Бага эрсдэлтэй-25/<br>Сентралскуэр ХХК /Бага эрсдэлтэй-17/<br>МИАТ ХК-Бизнес лоунж /Дунд эрсдэлтэй-34/<br>Талын монгол групп ХХК /Бага эрсдэлтэй-25/<br>Буянт-Ухаа ресторан-Бизнес лоунж, Вип заал /Дунд эрсдэлтэй-38/<br><br><u>Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтаар</u><br>Буянт-Ухаа трейд ХХК /Дунд эрсдэлтэй-36/<br>Номадс хоспиталити ХХК /Бага эрсдэлтэй-24/<br>Сентралскуэр ХХК /Бага эрсдэлтэй-24/<br>МИАТ ХК -Бизнес лоунж /Дунд эрсдэлтэй-45/ | Байнгын хяналт шалгалт сайжирна. | 1-3 дугаар улиралд | Хяналт шалгалт, эрсдэлийн удирдлагын хэлтэс |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Талын монгол групп ХХК /Дунд эрсдэлтэй-34/<br>Буянт-Ухаа ресторан-Бизнес лоунж, ВИП заал /Дунд эрсдэлтэй-54/ тус тус үнэлэгдэж шилэн хяналтын системд үр дүнг оруулсан. | | | |
| 2.2 Тандалт судалгааны чиглэлээр: | | | | | |
| 2.2.1 | ЭМЯ-ны Олон нийттэй харилцах, тандалт, шуурхай удирдлагын хэлтсээс "Олон улсад мэдээлэгдэж буй халдварт өвчний өдөр тутмын мэдээлэл"-ийг авах, APIS программаас орох чиглэлийн зорчигчдын мэдээллийг урьдчилан авч, тандалт судалгаа хийх, мэдээллийн сан үүсгэх. | Термокамерын хяналтаар 3964 агаарын хөлгийн 498340 зорчигчдын мэдээллийг APIS системээс урьдчилан авч, эрүүл мэндийн тандалт хийж ажилласан. | Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын /ахлах/ байцаагчид мэдээллээр хангагдаж, сэжигтэй тохиолдлын үед богино хугацаанд үнэлэх чадамж сайжирна. | 1-3 дугаар улиралд | Хяналт шалгалт, эрсдэлийн удирдлагын хэлтэс |
| 2.2.2 | Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллагын долоо хоног тутмын мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний мэдээнд тулгуурлан тандалт судалгаа хийж, болзошгүй эрсдэлийг тооцоолж, мэдээллийн сан үүсгэн ажиллах. | МХЕГ-ын 01/123 тоот удирдамжийн дагуу хийсэн хяналт шалгалтын хугацаанд тус боомтоор тахианы мах, махан бүтээгдэхүүн импортлогдоогүй. | Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчин тархахаас урьдчилан сэргийлнэ.<br>Мал эмнэлгийн хяналтын улсын /ахлах/ байцаагчид мэдээллээр хангагдана. | 1-3 дугаар улиралд | Хяналт шалгалт, эрсдэлийн удирдлагын хэлтэс |
| 2.2.3 | Европ, Газар дундын тэнгисийн Ургамал хамгааллын байгууллагын мэдээнд тулгуурлан тандалт судалгаа хийж, болзошгүй эрсдэлийг тодорхойлох. | МХЕГ-ын 02/146 тоот удирдамжийн дагуу ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнээр дамжин хорио цээртэй хөнөөлт организм дамжин тархахаас урьдчилан сэргийлэх хяналт хийсэн талаар тандалт судалгааг хийсэн. | Ургамлын гадаад болон дотоод хорио цээртэй хөнөөлт организм тархахаас урьдчилан сэргийлнэ.<br>Ургамлын хорио цээрийн хяналтын улсын /ахлах/ байцаагчид мэдээллээр хангагдана. | 1-3 дугаар улиралд | Хяналт шалгалт, эрсдэлийн удирдлагын хэлтэс |
| *Мэргэжлийн хяналтын байгууллагын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4 дүгээр зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд:*<br>**Гурав. "Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааны үр дүнтэй, шударга, шуурхай, ил тод байдлыг дээшлүүлэн, цахим системийг хөгжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх" зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээ:** | | | | | |
| 3.1 Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, сурталчлан таниулах, хэрэгжилт, үр дүнг хангуулна. | | | | | |
| 3.1.1 | Засгийн Газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, төлөвлөгөө, Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөр, УИХ, Засгийн газрын шийдвэрт тусгагдсан мэргэжлийн хяналтын байгууллагатай холбоотой заалтуудын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, эрх зүйн туслалцаа, | Агаарын тээврийг хялбаршуулах зөвлөлийн 2018-2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.2-т тусгасан "Хилийн боомтгүй нисэх буудалд агаарын хөлөг буулт үйлдсэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний | Мөрийн хөтөлбөр, төлөвлөгөөний заалтууд хэрэгжсэн байна.<br>Албан хаагчдад шаардлагатай хууль эрх зүйн туслалцаа үйлчилгээг үзүүлсэн байна.<br>Зөрчлийн талаарх гомдол | Жилдээ | Захиргаа, удирдлагын хэлтэс |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | зөвлөгөө үзүүлэх, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн нэгдсэн бүртгэл хөтлөх. | нэгдсэн журам"-ын төсөлд холбогдох саналыг хүргүүлж ажилласан болно. | мэдээллийн бүртгэлийг хөтөлсөн байна. | | |
| 3.2 Байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилтийг хангаж, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, цаашдын зорилтыг тодорхойлно. | | | | | |
| 3.2.1 | Албаны дотоод үйл ажиллагааг зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах. | Албаны үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан. | Албаны үйл ажиллагааны шуурхай байдал хангагдаж, ажлын үр дүн дээшилнэ. | Жилдээ | Захиргаа, удирдлагын хэлтэс |
| 3.2.2 | Албаны архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандартын дагуу хөтлөн явуулж, төрийн үйлчилгээг иргэд, аж ахуйн нэгж байгууллагад шуурхай хүргэх | Албаны архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандартын дагуу хөтлөн явуулж байна. | Архив албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг зохих заавар журмын дагуу явуулна.<br>Иргэд байгууллагаас ирүүлсэн албан бичиг, өргөдөл хүсэлтийг холбогдох журмын дагуу шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулж ажилласан байна.<br>Архивын нэгжийн цахим сан үүсгэсэн байна. | Жилдээ | Захиргаа, удирдлагын хэлтэс |
| 3.2.3 | Албаны үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийж, үйл ажиллагааны үр дүнд үнэлэлт, дүгнэлт өгөх | Албаны үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан. | Албаны хяналт шалгалтын болон дотоод үйл ажиллагаа сайжирсан байна.<br>Ажил сайжруулах арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна. | Жилдээ | Захиргаа, удирдлагын хэлтэс |
| 3.3 Хүний нөөцийн үйл ажиллагааг зохион байгуулах, удирдлага, арга зүйгээр хангана. | | | | | |
| 3.3.1 | Албаны үйл ажиллагаа, зохион байгуулалтыг Төрийн албаны тухай */шинэчилсэн найруулга/* хуульд нийцүүлэх ажлыг төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, зохион байгуулах, хэвшүүлэх | Албаны үйл ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулсан. | Хүний нөөцийн үйл ажиллагааг шинээр батлагдсан хууль журмын дагуу зохион байгуулж, сул орон тоог нөхнө.<br>Төрийн албан хаагчдыг чадахижуулах сургалтын төлөвлөгөө гарган хэрэгжүүлсэн байна.<br>Төрийн албан хаагчдын нийгмийн баталгаа, ажиллах орчин нөхцлийг сайжруулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.<br>Албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн баталсан байна.<br>Албан хаагчдын сахилга | Жилдээ | Захиргаа, удирдлагын хэлтэс |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ. | | |
| 3.3.2 | Авилгын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах | Авилгаас ангид байх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж байна. | Авлигын эсрэг хуулийн хэрэгжилт хангагдана. | Жилдээ | Захиргаа, удирдлагын хэлтэс |
| 3.4 Санхүүгийн удирдлага, төлөвлөлт, гүйцэтгэлд тавих хяналтыг чангатгаж, үр дүнг тайлагнах, шилэн дансны бүртгэлийн хөтлөлт, үнэн зөв байдлыг хангаж ажиллана. | | | | | |
| 3.4.1 | Албаны 2020 оны төсвийн төслийг батлуулах, 2021-2022 оны дунд хугацааны төсвийн төлөвлөлтийг боловсруулан, холбогдох байгууллагад хүргүүлэх | Тус албанд 2018 онд 1.457.121.400 төгрөгийн төсөв батлагдан санхүүжилтийг бүрэн авч 80 хувийн гүйцэтгэлтэй ажилласан. | Төсвийн төслийг бодитой төлөвлөж ажиллана. | 2-3 дугаар улиралд | Захиргаа, удирдлагын хэлтэс |
| 3.4.2 | Албаны худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу цахим хэлбэрээр хэрэгжүүлэх | 2018 онд батлагдсан төсвийн хүрээнд урсгал зардлаас нээлттэй тендер шалгаруулалт 1, харьцуулалтын аргаар 3 тендер тус тус Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулан ажилласан. | 2019 онд шатахууны худалдан авах үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулна. | 1-2 дугаар улиралд | Захиргаа, удирдлагын хэлтэс |
| 3.4.3 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулан сайтын хөтлөлтөд улирал бүр бүртгэлээр хяналт тавьж ажиллах | Шилэн дансанд улирал бүр хяналт тавьж зөрчлийг арилгуулан ажилласан. | Шилэн дансны хуулийн хэрэгжилт сайжирч санхүүгийн ил тод байдал хангагдана. | Улирал бүр | Захиргаа, удирдлагын хэлтэс |
| 3.4.4 | Албаны хэмжээнд шаардлагатай материалын хангалтыг цаг хугацаанд нь хийх, хуваарилалт болон зарцуулалт, хөрөнгийн хөдөлгөөн, мөнгөн хөрөнгийн эргэлтэд өдөр тутам хяналт тавин нөөцийг зохицуулж тайлагнах | Ажилтнуудад хангалтын материал, бичиг хэрэг, маягт, хэвлэмэл материал, аж ахуйн хэрэгцээний материал, сэлбэг хэрэгсэл, түлш, шатах тослох материал, хангамжийн материалаар хангаж ажилласан. | Шаардлагатай материалын хангалтыг цаг хугацаанд нь хийж, хуваарилна. | Тогтмол | Захиргаа, удирдлагын хэлтэс |
| 3.5 “Эрүүл мэндийн асуудалтай холбоотой үүссэн онцгой байдал” КОД-9 бүрэн хэмжээний дасгал сургуулилтыг зохион байгуулах. | | | | | |
| 3.5.1 | “Эрүүл мэндийн асуудалтай холбоотой үүссэн онцгой байдал” КОД-9 бүрэн хэмжээний дасгал сургуулилтыг зохион байгуулах. | ОУЭМД-ээр зохицуулагддаг Хүний хөл хориот халдварт өвчин нэвтрэхээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд сургалт зохион | Халдвар эсэргүүцэх хариу арга хэмжээний бэлэн байдал хангагдана. | Жилдээ | Захиргаа, удирдлагын хэлтэс<br><br>Хяналт |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | байгуулсан /1 удаа/. | | | шалгалт, эрсдэлийн удирдлагын хэлтэс |
| 3.6 Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлыг ашиглалтанд орохтой холбогдуулан ХМХА-ны нүүлгэн шилжүүлэлтийн ажлыг зохион байгуулах, холбогдох байгууллагатай хамтран ажиллах. | | | | | |
| 3.6.1 | Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлыг ашиглалтанд орохтой холбогдуулан ХМХА-ны нүүлгэн шилжүүлэлтийн ажлыг зохион байгуулах, холбогдох байгууллагатай хамтран ажиллах. | Иргэний нисэхийн ерөнхий газрын 2018 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 02/498 тоот албан бичгийн дагуу “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын үйл ажиллагааг нүүлгэн шилжүүлэх, нисэх буудлын үйл ажиллагааны хэвийн, тасралтгүй байдлыг хангах зорилгоор 5 дэд бүлэг 20 ажил бүхий төлөвлөгөө боловсруулж биелэлтийг хангуулж ажилласан | Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудалд шилжин ажиллах ХМХА-ны үйл ажиллагаа жигдэрсэн байна. | Жилдээ | Захиргаа, удирдлагын хэлтэс<br><br>Хяналт шалгалт, эрсдэлийн удирдлагын хэлтэс |
| 3.7 Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, албаны үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, олон нийтийг мэдээллээр хангах замаар эрсдэлээс урьдчилан сэргийлнэ. | | | | | |
| 3.7.1 | Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх. | БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотын “Байта” ОУНБ-ын Хилийн хорио цээрийн байгууллагатай хамтран ажиллаж байна.<br>“Туркийн хамтын ажиллагаа, зохицуулах агентлаг”-тай хамтран ажиллах талаар судалж, төсөл бичих зөвлөмж авсан. | Гадаад хамтын ажиллагаа өргөжинө. | Жилдээ | Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс |
| 3.7.2 | Албаны үйл ажиллагаа, хяналт шалгалтын үр дүнг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилах. | “Буянт-Ухаа Хилийн мэргэжлийн хяналтын алба” фэйсбүүк пэйж хуудас болон www.border.gov.mn сайтад сэрэмжлүүлэг, зөвлөмж-109, үйл явдлын мэдээ, фото сурвалжлага-26, “Мэргэжлийн хяналтын ерөнхий газар” фэйсбүүк хуудсанд 18 зөвлөмж байршуулсан.<br>“Чингис хаан” ОУНБ-ын www.airport.gov.mn сайттай хамтран ажиллаж, тус сайтын | Байгууллагын үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй, ил тод болно. | Жилдээ | Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | “Хилийн мэргэжлийн хяналтын алба” цэсний мэдээллийг шинэчлэн, 2018 оны 09 дүгээр сард 3 зөвлөмж байршуулсан. | | | |
| 3.7.3 | Эрсдэл аюулаас урьдчилан сэргийлэх, иргэд, хэрэглэгчдийг соён гэгээрүүлэх, зөвлөн туслах зорилгоор “Сарын аян” -ыг зохион байгуулах | “Хилийн хяналт-Иргэн Таны оролцоо” сарын аяны нээлтийн арга хэмжээг “Чингис хаан” ОУНБ-д зохион байгуулсан. | Байгууллагын үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй, ил тод болно. | Жилдээ | Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс |

| | | | |
|---|---|---|---|
| Төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллах: | Буянт-Ухаа боомт дахь ХМХА-ны дарга<br>*(Албан тушаал)* | ................................ Б.Отгонцэцэг<br>*(Овог нэр, гарын үсэг)* | 2019.01.25<br>*(Огноо)* |

ТТБ2501 9128778